



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 09 сарын 06 өдөр

Дугаар 2/00

Улаанбаатар хот

Г Томилгоот хуваарьт шилжүүлэх тухай Г

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.16, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2019 оны "Хуваарь батлах тухай" 182 дугаар тушаал, Онцгой байдлын Ерөнхий газрын дэд даргын 2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 2.2/2012 тоот үүргийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газар, Бүгд найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн хүрээнд нийлүүлэгдэн Баянзүрх, Хан-Уул, Сүхбаатар дүүргийн онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах аврах 14, 34, 74, 63 дугаар ангиудад хуваарилагдсан гал унтраах үндсэн албаны 4 ширхэг автомашиныг 2019 оны 09 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн томилгоот хуваарьт оруулсугай.

2. Шатахуун, тосны зарцуулалтыг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2007 оны "Нормчлол шинэчлэн батлан тухай" тушаалын нэгдүгээр хавсралтад заасны дагуу 2013 онд нийлүүлэгдсэн Исузу 3,5 тоннын автомашинуудтай нэгэн адил буюу 100 километрийн гүйлтэд зарцуулах шатахууныг 40 литр, гал түймэр, гамшиг ослын голомтод ажиллах, дадлага сургууль хийх үед тусгай тоног төхөөрөмж ажиллуулахад 1 цагт 30 литр, бэлэн байдал хангах зүгшрүүлэлт хийх асаалтыг 9 литрээр тооцож бэлэн байдлыг хангуулж ажиллахыг Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтэс (дэд хурандаа В.Батсайхан), Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтэс (хурандаа Д.Даваасүрэн), Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтэс (дэд хурандаа Д.Бэхбаяр)-т тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга (дэд хурандаа Н.Нямхорлоод)-д даалгасугай.

ДАРГА,  
ХУРАНДАА  Ж.НҮЛТЭМСҮРЭН

